



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 136

Улаанбаатар хот

Хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, 2022 оны 204 дүгээр тогтоолын 1, 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүй, дотоод хэргийн яамны хөрөнгөд бүртгэлтэй, 140,195,000.00 (нэг зуун дөчин сая нэг зуун ерэн таван мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Хүний эрхийн үндэсний комисст балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Хүний эрхийн үндэсний комиссын Тамгын газрын дарга Ц.Адьяахишиг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Автомашиныг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132861390

14-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 25 дугаар сарын 16-ны өдрийн
416 дугаар тогтоолын хавсралт



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССТ БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ (автомашин)

Д/д	Хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Автомашин, Хьюндай стариа, 12-10 УБН (арал-kmjyd374bru178300)	2023.04.23	140,195,000.00
	Нийт дүн		140,195,000.00 (нэг зуун дөчин сая нэг зуун ерэн таван мянга)